



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2022.04.13 № 16

Асуулга тавих тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг багасгана” гэж заасан байдаг. Үүний дагуу Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Энэтхэг Улс (БНЭУ)-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадал бүхий газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэхүү төслийг БНЭУ-ын “Инженерс Индиа Лимитэд” компани гүйцэтгэж байна.

Стратегийн бүтээгдэхүүн болох түлш, шатахууныг дотооддоо үйлдвэрлэснээр энэ төрлийн бүтээгдэхүүний импортын хэмжээг багасгах, улмаар эдийн засгийн хувьд бусад орноос хараат байдлыг бууруулах, гадагшаа гарч буй их хэмжээний мөнгөн урсгалыг дотооддоо авч үлдэн, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Гэвч Монгол Улсын Засгийн газраас оруулах хөрөнгө оруулалтыг үр дүнтэй зарцуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих шаардлагатай байна.

Иймд Улсын Их Хурлын гишүүн миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т тус тус заасныг үндэслэн, Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй холбогдуулан Танд хандан дараах асуулгыг тавьж байна.

1. Газрын тос боловсруулах үйлдвэр нь жилд 1,5 сая/тн тос боловруулах хүчин чадалтай байна гэж ТЭЗҮ-дээ заасан байдаг. Одоогоор газрын тос олборлож буй Тамсаг дахь 19, 21 дүгээр талбай болон Дорноговь аймгийн БХГ-97 дугаар талбай нийлээд ашиглалтын баталгаажсан 43 сая тн орчим нөөцтэй нь үйлдвэрийг 30 орчим жил түүхий эдээр хангахаар харагдаж байна. Тэгвэл цаашид шинэ орд нээж, түүхий тосны нөөц, олборлолтыг нэмэгдүүлэх чиглэлээр ямар арга хэмжээ төлөвлөж байгаа талаар;

2. Тамсагийн талд хэдийнэ илэрсэн газрын тосны ордуудыг бүрэн ашиглалтад оруулж, олборлолт хийлээ гэхэд тухайн бүс нутаг дахь эрчим хүчний хангамж хүрэлцэхгүй. Тэгвэл эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох, хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр ямар арга хэмжээ авч байгаа талаар;

3. Газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэхэд хадгалах агуулах хангалтгүй байгаа талаар салбарынхан нь мэдээлэл өгсөн. Тэгвэл агуулах шинээр барьж, ашиглалтад оруулах чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй талаар;

4. Газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулснаар:

- Дотоодын түлш, шатахууны хэрэгцээний хэдэн хувийг хангах,
- Гадагш гарах валютын урсгалыг хэдэн хувиар бууруулах,
- Дотоодын нийт бүтээгдэхүүн болон улс, орон нутгийн төсвийн орлого хэдэн хувиар өсөх,
- Газрын тосны үйлдвэр болон туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдэд нийт хичнээн ажлын байр шинээр бий болох зэрэг талаар;

5. Үйлдвэрийн гаднах дэд бүтэц болох түүхий газрын тос дамжуулах хоолой, 27 км салаа төмөр зам, 18,2 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 17,5 км хүнд даацын автозам мөн ажилчдын хотхон байгуулах үүргийг Монгол Улсын Засгийн газар хүлээж байгаа. Эдгээрээс хамгийн том хөрөнгө оруулалт шаардагдаж буй бүтээн байгуулалтын ажил болох “Газрын тос дамжуулах хоолойг санхүүжүүлж, барих төсөл”-ийн ТЭЗҮ-ний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;


6. Дээрх төслийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад хичнээн улсын хэдэн компани оролцсоноос ямар үндэслэлээр БНХАУ-ын “NORINCO International Cooperation” ХХК-ийг сонгон шалгаруулсан талаар;

7. БНХАУ-ын “NORINCO International Cooperation” ХХК нь газрын тос дамжуулах хоолойг 397 сая ам.доллараар барих үнийн санал өгсөн бөгөөд оруулсан хөрөнгө оруулалтаа “Эрдэнэс-Тавантолгой” ХК-аас худалдан авах нүүрсээр тооцон буцаан авах гэрээ хэлцэл хийгдэж байгаа талаар мэдээлэл байна. Тэгвэл энэ хэлцлээр нүүрсний үнийг хэдээр тооцож байгаа болон энэ нь олон улсын зах зээлийн жишиг үнэд нийцэж буй эсэх талаар;

8. Газрын тос дамжуулах хоолойгоор 560 км зам туулан үйлдвэрт нийлүүлэгдэх газрын тосны тээвэрлэлтийн өртөг хэд болох талаар /шоо метр тутамд/ тус тус дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэж ирүүлнэ үү.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах бэлтгэлийг хангаж ажиллахыг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



НАЯНТАЙН ГАНИБАЛ

2022000023